



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/109

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын Их Хурлын "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020 оны 52 дугаар тогтоол, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "АЛСЫН ХАРАА-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.1 дэх зорилт, Монгол улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулах гэрээний 1.5 дахь заалт, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.4.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Соёл урлагийн салбарын "Алтайн соёлын сэргэлт" арга хэмжээний нэгдсэн хэлэлцүүлэг, хүний нөөцийг чадавжуулах сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Соёл урлагийн газар (С.Цагаанбаатар)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.АМГАЛАНБААТАР